



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 327

Улаанбаатар хот

**Шалгалтын мөрөөр авах
арга хэмжээний тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Цагаан шонхор” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 он, 2019 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус үйлдвэрийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлд заасныг зөрчин 47,508.10 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ НЬ:

1. “Цагаан шонхор” төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Цагаан шонхор” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Ариунзаяад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

2.2. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахыг таслан зогсоох;

2.3. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, 2018 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 281 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах;

2.4. Үйлдвэрийн газрын эзэмшиж буй газрын зориулалтыг үйл ажиллагааны зориулалтын дагуу өөрчлүүлэн, эд хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлд бүртгүүлэх;

2.5. Тогооолын биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА



ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

3. МЭНДСАЙХАН

Ц. ТҮВШИНЗАЯА

900594

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн
тогтоолын хавсралт



“Цагаан шонхор” төрийн өмчит үйлдвэрийн газарт хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Мөнгөн дүн /мянган төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт	Захирал Б.Ариунзаяа Ерөнхий ня-бо Ц.Цэнгэлмаа	Гаралт, 2020 2020 47,508.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, 2018 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 281 дүгээр тушаалтыг тус тус мөрдөж ажиллах
	Нийт дүн		47,508.10	

ооо